



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 02

Чингис хот

Шалгалтын комисс байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.2.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.3, 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 3.1, 3.2, 3.3, 6.1, 7.1, 2020 оны 141 дүгээр “Төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах шалгалтын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Шалгалтын комиссын дарга:	Ж.Гантулга	Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүн:	Б.Сүнгээ	Салбар зөвлөлийн гишүүн, Мэргэжлийн хяналтын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Ж.Саруултөгс	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Төрийн албаны тусгай шалгалтыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулахыг шалгалтын комиссын дарга /Ж.Гантулга/-д даалгасугай.

3. Төрийн албаны тусгай шалгалтын тайлан, судалгааг хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг нарийн бичгийн дарга /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР